

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

№ 22/31

Улаанбаатар хот

### Компанийн Гүйцэтгэх захирал чөлөөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.6 дахь заалт, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ГУЗ”)-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ЗХ-22/02 тоот дүгнэлт, Компанийн ГУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх захирал Б.Удвалаас 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр гаргасан ажлаас чөлөөлөгдөх тухай хүсэлт, Компанийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ЗХ-22/02 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн Компанийн Гүйцэтгэх захирал Б.Удвалын бүрэн эрхийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон дуусгавар болгож, үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Б.Удвалыг өөрийнх нь хүсэлтээр Компанийн Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас нь чөлөөлж буйтай холбогдуулан түүнтэй байгуулсан гэрээг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон дуусгавар болгосугай.
3. Компанийн Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор дараагийн томилогдсон Гүйцэтгэх захиралд хүлээлгэн өгөхийг Б.Удвалд даалгасугай.
4. Б.Удвалд холбогдох цалин хөлс, ээлжийн амралтын тооцоог 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хийн олгох, Компанийн ГУЗ-өөс шийдвэрлэсний дагуу гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг тооцож олгох, ийнхүү олгохдоо холбогдох хууль тогтоомжид заасан татвар, шимтгэлийг суутгахыг Компанийн Ерөнхий нягтлан бодогч (Г.Золжаргал)-д үүрэг болгосугай.



# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

№ 22/32

Улаанбаатар хот

## Компанийн Гүйцэтгэх захирал томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ГУЗ”)-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ЗХ-22/03 тоот дүгнэлт, Компанийн ГУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх захирлаар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Цэрэндорж овогтой Ууганбаяр (РД: РУ89010304)-ыг томилсугай.
2. Монгол Улсын Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Компанийн ГУЗ-ийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
3. Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-тай Компанийг төлөөлөн холбогдох гэрээг байгуулан ажиллахыг Компанийн ГУЗ-ийн Дарга (О.Болдбаатар)-д даалгасугай.
4. Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр) нь холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм болон түүнтэй байгуулсан гэрээнд заасан, мөн ГУЗ-өөс олгосон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ гүйцэтгэх болохыг тэмдэглэсүгэй.
5. Компанийн Гүйцэтгэх захирал томилогдсонтой холбоотойгоор Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулан олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх, холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг Компанийн ГУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд), Компанийн Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан мэргэжилтэн (Х.Одончимэг) нарт үүрэг болгосугай.





## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2023.01.17 № ЦМ-7/003 .

танай 2023.01.06 -ны № 05/12 -т

Г

### “ЛЭНДМН ББСБ” ХХК-Д

Г

“Лэндмн ББСБ” ХХК-ийн гүйцэтгэх захирлыг өөрчлөх хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авч, хянаж үзэхэд гүйцэтгэх захирлаар томилохоор ирүүлсэн Цэрэндорж овогтой Ууганбаяр нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа тул гүйцэтгэх захирал Б.Удвалыг өөрчилж, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох бүртгэлд бүртгэсэн болно.

Гүйцэтгэх захирал өөрчлөгдсөнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэж, холбогдох баримт бичгийг ажлын 10 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг мэдэгдье.



## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

№ 22/33

Улаанбаатар хот

### Гэрээ батламжлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийг Компанид төвлөрүүлэх зорилгын хүрээнд “АНД Системс” ХХК-аас тухай бүр шаардлагатай төгрөгийн болон ам.долларын санхүүжилт авахаар 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр “АНД Системс” ХХК-тай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-г хүлээн зөвшөөрч, баталгаажуулсугай.
2. “Санхүүжилтийн гэрээ”-ний үндсэн нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар батламжилсугай.
3. Цаашид зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан “Санхүүжилтийн гэрээ”-ний үндсэн нөхцөлд өөрчлөлт оруулах, эдгээртэй холбоотой гэрээ хэлцлийг байгуулах эрхийг Компанийн гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Гэрээний хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тухай бүр эргэн тайлагнахыг Компанийн гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

